



ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ

БИДНИЙ ҮҮРЭГ АМЛАЛТ:

- Олон төрлийн дэмжлэгийн хөтөлбөрөөр дамжуулан малчдын уламжлалт амьжиргааг дэмжих
- Нүүлгэн шилжүүлэлт, буцалтгүй тусламжийн тэгш нөхцөл, хугацааг санал болгох.

ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ:

- 2005 онд 16 гэр бүл бүхий 10 айлыг нүүлгэн шилжүүлсэн (нийт 61 хүн)
- 89 өрх буюу 80 гэр бүл, нийт 365 хүн эдийн засгийн хувьд нөлөөнд өртсөн.

БИДНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:

МАЛЧДЫГ ДЭМЖИХ:

- Монгол Улсад анхлан хэрэгжиж буй малчдад дэмжлэг үзүүлэх олон төрлийн хөтөлбөр нь Оюу Толгойн амлалтын дагуу олон улсын стандартыг мөрдөн дэмжлэг үзүүлж чадаж буй эсэхийг баталгаажуулан хангах.





НАРИЙВЧИЛСАН ҮЙЛ ЯВЦЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД ДАРААХЬ АЖЛУУДЫГ ХИЙГЭЭД БАЙНА . ҮҮНД:

- Нөлөөллийн бүсийг тогтоох
- Нөлөөллийн бүс бүрийн нөлөөлөлд өртөж буй өрхүүдийн тухай мэдээллийг цуглуулан нэгтгэх
- Суурь мэдээлэл болон нөлөөллийн үнэлгээн дээр үндэслэн нөхөн олговрын шаардлагуудыг үнэлсэн
- Орон нутгийн иргэдэд үзүүлж буй нөлөөллийг бууруулахын тулд олон жилийн туршид өргөн хүрээний хэлэлцүүлгийг орон нутгийн ард иргэд, сумын удирдлагуудыг оролцуулан явуулсан
- Нүүлгэн шилжүүлэлт болон нөхөн төлбөрийн арга зүй, нөхцөл болон хугацааг дахин хянан үзэх зорилгоор бие даасан шинжээчдийг хамруулан оролцуулсан
- Олон нийтийн санааг зовоож буй асуудлуудыг тодруулсан.

Хөтөлбөрийн үр дүнг цаашид үргэлжлүүлэн хянан шинжилж, үнэлэх болно.

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮЙЛ ЯВЦ БОЛОН ҮНЭЛГЭЭНИЙ ЯВЦАД ТОГТООГДСОН НӨЛӨӨЛЛҮҮДИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД ДАРААХЬ АЖЛЫГ ХИЙГЭЭД БАЙНА. ҮҮНД:

- Малчдын өвөлжөө байрлаагүй газрыг нисэх буудал барихад зориулан сонгон авсан
- Малчид, мал болон амьтанд үзүүлэх нөлөөллийг бууруулахад чиглэсэн маршрутаар Оюу Толгой – Гашуун Сухайтын хатуу хучилтат зам тавихаар сонгон авсан
- Зуны бэлчээрт үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор усны хоолойг газарт булж суурилуулан, тухайн газрыг нөхөн сэргээж, ургамалжуулсан (цаашид үргэлжлүүлэн хийх болно)
- Сумын засаг захиргаа, Монголын бэлчээрийн менежментийн холбоо, орон нутгийн бэлчээр ашиглалтын ТББ болох Ханбогд Алтан Нутаг байгууллага, орон нутгийн малчидтай хамтран Оролцоонд түшиглэсэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн.

ШИЛЖИН СУУРЬШСАН БОЛОН НӨЛӨӨЛӨЛД ӨРТСӨН ӨРХҮҮДЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ НЭМЭЛТ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД ДАРААХЬ АЖЛУУДЫГ ХИЙГЭЭД БАЙНА. ҮҮНД:

- Олон Улсын Санхүүгийн Корпорацийн стандартын дагуу Малчдыг шилжүүлэн суурьшуулах хөтөлбөр, нөхөн олговрын багцыг олгосон
- Сургуулийн тэтгэлэг, малчдад орлогын шинэ эх үүсвэрийг бий болгоход туслалцаа үзүүлэх, бичил зээл олгох, богино хугацааны сургалт, бэлчээрийн усан хангамжийн туслалцаа зэргээр нэмэлт дэмжлэг туслалцааг үзүүлсэн
- Хүнсний ногоо тариалах, ингэний сүү боловсруулах зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн 53 бизнест дэмжлэг үзүүлсэн.

Түүнчлэн малчдын ашигладаг 20 гар худгийг сэргээж, малчдад байнгын ажилтай болоход нь бэлтгэх чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлж эхлээд байна.



Дэлгэрэнгүй мэдээллийг Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд (БОННУ) тусгагдсан тусгагдсан Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс үзнэ үү.

БОННУ-г www.ot.mn цахим хуудас болон дор дурьдсан олон нийтийн газруудаас авч болно:

- Ханбогд, Манлай, Баян-Овоо болон Даланзадгад сумд дахь Оюу Толгойн салбар оффис
- **Ханбогд сум:** Ёслолын Өргөө
- **Манлай сум:** ЗДТГ-ын Мэдээллийн танхим
- **Баян-Овоо сум:** Дунд сургууль
- **Даланзадгад:** Төв номын сан болон Иргэний танхим
- **Улаанбаатар:** Оюу Толгойн Мэдээллийн Төв.